



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 32

Хэрлэн сум

М.Солонгыг төрийн жинхэнэ
албаны нөөцөд бүртгэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1, 62.1.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-ын 2.1.1, 3.3-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэнд хариуцсан ахлах мэргэжилтэн Мөнхбадрахын Солонго нь өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын ангилал, зэрэглэл өөрчлөгдсөн тул төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэсүгэй.

2. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын дагуу М.Солонгыг нөөцийн бүртгэлд бүртгэхийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Эрдэнжаргал/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР